



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 12 өдөр

Дугаар A/46

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.4, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ЦССҮТ/20250102005 тендер шалгаруулалтын дугаартай “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл арга хэмжээний “Багц №15: Гемофилийн эсрэг рекомбинант VIII, IX фактор” нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зохион байгуулалтын үйл ажиллагаа дуусаагүй байгаатай холбогдуулан ЦССҮТ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны ЦССҮТХАГ/24-11 дугаартай “Гемофилийн эсрэг рекомбинант VIII, IX фактор” нийлүүлэх гэрээний анх байгуулсан нөхцлөөр нэмэлт гэрээ байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга (Ч.Батболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засагч (Л.Өнөрбаяр)-т даалгасугай.


ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

1308010263

Захирлын 2025 оны 08 дугаар
сарын 11 өдрийн 146 дугаар
тушаалын хавсралт



ЦССҮТ-ИЙН 2024 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЦССҮТХАГ/24-11 ДУГААРТАЙ "ГЕМОФИЛИЙН ЭСРЭГ РЕКОМБИНАНТ VIII, IX
ФАКТОР" НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Захиргаа, маркетингийн албаны дарга
Ч.Батболд

Нарийн бичиг:

Эдийн засагч Л.Өнөрбаяр

Гишүүд:

Цусны чанар, аюулгүй байдлын албаны
дарга Э.Тунгалагтуяа

Санхүү, бүртгэлийн албаны дарга Х.Одгэрэл

Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч Б.Оргил

Үйлдвэрлэлийн тасгийн технологич их эмч
Н.Халиун

Санхүү, бүртгэлийн албаны Тооцооны
нягтлан бодогч Б.Алтанзул